



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 369

Улаанбаатар хот

Хөрөнгө дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 10 нэрийн нийт 265,684,800.00 (хоёр зуун жаран таван сая зургаан зуун наян дөрвөн мянга найман зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Ажлын хэсэг томилон үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу байгууллагын дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашины улсын дугаарыг шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн омчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 07 дугаар сарын 06-ний
өдрийн 369 дугаар тогтоолын хавсралт

**ИНЕГ-ын /Газрын үйлчилгээний алба/ үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй
дуудлагын худалдаагаар худалдах тээврийн хэрэгсэлийн жагсаалт, худалдах
доод үнэ**

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	УАЗ-2206 маркийн, 59-02 УББ улсын дугаартай, суудлын, арлын дугаар- 37410040414936	2003/2004	556930	9,850,000.00	1,525,437.52	1,600,000.00
2	УАЗ-3303 маркийн, 61-39 УБД улсын дугаартай, хагас ачааны, арлын дугаар- 30473256	2003/2003	166884	9,537,000.00	1,857,250.00	1,900,000.00
3	УАЗ-3303 маркийн, 38-31 УБМ улсын дугаартай, ачааны, арлын дугаар-0040415553	2004/2004	387613	8,700,000.00	3,814,818.00	3,500,000.00
4	УАЗ-315142 маркийн, 45-81 УНЛ улсын дугаартай, арлын дугаар-0563292	2010/2011	384799	19,400,000.00	1,460,363.00	1,500,000.00
5	Aerotown маркийн, 6566 УБМ улсын дугаартай, арлын дугаар- KMJNN19AP2C307518	2002/2002	600541	74,250,000.00	5,036,704.00	5,000,000.00
6	Country маркийн, 62-72 УНП улсын дугаартай, автобус, арлын дугаар- KMJHD17PP5C027099	2005/2006	736563	49,500,000.00	7,059,135.00	7,000,000.00
7	ГКБ-817 маркийн, 74-60 ТЧ улсын дугаартай, чиргүүл, арлын дугаар- 145323	1990/2008	433392	280,000.00		200,000.00
8	МоАЗ-546 маркийн, 47-40 УН улсын дугаартай, шороо зөөгч, арлын дугаар- 20950	1987/1993	18855.4 м/цаг	2,584,000.00	5,612,626.00	5,500,000.00
9	В-13Т маркийн, 33-50 УБА улсын дугаартай, ачаа тээш өргөгч арлын дугаар- CF00007	2000/2000	49095 м/цаг	59,583,800.00	220,000.00	220,000.00
10	ЭО-2321 маркийн, 79-86 УН улсын дугаартай, экскаватор, арлын дугаар- 8200465	2004/2004	6396 м/цаг	32,000,000.00		3,000,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			265,684,800.00 (хоёр зуун жаран таван сая зургаан зуун наян дөрвөн мянга найман зуун)	26,586,333.52 (хорин зургаан сая таван зуун наян зургаан мянга гурван зуун гучин гурван төгрөг тавин хоёр мөнгө)	29,420,000.00 (хорин есөн сая дөрвөн зуун хорин мянган)